

**БҮСИЙН ОНОШИЛГОО ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

| №                                                                                                  | Үйл ажиллагаа                                                                                                         | Шалгуур үзүүлэлт           | Суурь түвшин                | Хүрэх түвшин                | Хэрэгжилт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | Үнэлгээ |
|----------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------|-----------------------------|-----------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------|
| <b>Нэг. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах чиглэлээр</b> |                                                                                                                       |                            |                             |                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |         |
| 1.2                                                                                                | Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг даргын 2024 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж, тайлагнах | Гэрээний хэрэгжилтийн хувь | 85                          | 90                          | ЭМСайд Засаг даргатай байгуулсан 2025 оны гэрээний хэрэгжилтийг хагас жил тутам үнэлж ажилласан бөгөөд эхний хагас жилийн гүйцэтгэл 70.8%, Тайлант хугацаанд нийт 42 үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж жилийн эцсийн гүйцэтгэл 90%үнэлэгдсэн.                                                                                                                                                                                                                                         | 90%     |
| 1.3                                                                                                | Эрүүл мэндийн сайдын тушаал, албан даалгавар, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж тайлагнах  | Хэрэгжилтийн хувь          | ЭМС 95, албан даалгавар 100 | ЭМС 95, албан даалгавар 100 | Эрүүл мэндийн сайдын 29 тушаал, 8 албан даалгаврыг бүртгэл хяналтад авч эмч нарын ярианд танилцуулж холбогдох тасаг нэгжүүд рүү шилжүүлэн хэрэгжилтэд улирал тутам хяналт тавьж ажиллалаа. Шинээр батлагдсан эмнэлзүйн удирдамжийг хэрэгжүүлэх арга хэмжээг тасгийн эрхлэгчийн хариуцлагын гэрээнд тусган үнэлж байгаа нь ололттой тал байв. Хяналт үнэлгээний үр дүнг илтгэх хуудсаар байгууллагын Захиралд танилцуулж дэд захирлууд, албадын дарга нарт зөвлөмж хүргүүлэн ажилласан. | 100     |
| 1.4                                                                                                | Бодлогын бичиг баримтын хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж тайлагнах                                                     | Хэрэгжилтийн хувь          | 90                          | 95                          | Монгол улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль тогтоомжийн хэрэгжилт, аймгийн ЗД-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Орхон аймгийн                                                                                                                                                                                                                                                                                                                   | 90      |

|     |                                                           |                              |      |     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |     |
|-----|-----------------------------------------------------------|------------------------------|------|-----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
|     |                                                           |                              |      |     | хөгжүүлэх 2025 оны төлөвлөгөөний биелэлт, ИХ-ын тогтоол шийдвэр, Засаг даргын захирамж нийт 6 бодлогын бичиг баримтыг бүртгэл хяналтад авч хэрэгжилтэд хагас бүтэн жилээр үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлэн ажиллалаа. Хяналт үнэлгээний үр дүнг илтгэх хуудсаар байгууллагын Захиралд танилцуулж дэд захирлууд, албадын дарга нарт зөвлөмж хүргүүлэн ажилласан. Хэрэгжилтийн дундаж хувь 90%                    |     |
| 1.5 | БОЭТ-ийн захирлын 2025 оны А тушаалын хэрэгжилтийг үнэлэх | Шийдвэрийн хэрэгжилтийн хувь | 82.4 | 90  | Тайлант хугацаанд БОЭТ-ийн Захирлын 93 А тушаалыг бүртгэл хяналтад авч хэрэгжилтэд хяналт тавин ажилласан. Захирлын А тушаалын 97 хувийг удирдлага зохион байгуулалтын агуулгатай тушаал эзэлж байв. Хяналт үнэлгээний үр дүнг илтгэх хуудсаар байгууллагын Захиралд танилцуулж дэд захирлууд, албадын дарга нарт зөвлөмж хүргүүлэн ажилласан.                                                                | 90  |
| 1.6 | БОЭТ-ийн захирлын 2025 оны Б тушаалын хэрэгжилтийг үнэлэх | Шийдвэрийн хэрэгжилтийн хувь | 96   | 100 | Тайлант хугацаанд БОЭТ-ийн Захирлын 493 Б тушаалыг бүртгэл хяналтад авч хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. Захирлын Б тушаалын 8.7% өөрийн саналаар ажлаас гарах, 3% нь буцалтгүй тусламж, тэтгэмжтэй холбоотой, 10.9% нь чөлөө олгосон, үүнээс олговортой чөлөө 6.3%, олговоргүй чөлөө 4%-ийг тус тус эзэлж байв. Хяналт үнэлгээний үр дүнг илтгэх хуудсаар байгууллагын Захиралд танилцуулж дэд захирлууд, | 100 |

|                                                                                                 |                                                                                                                                                                   |                                 |      |     |                                                                                                                                                                                                                                                                                                                                     |    |
|-------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------|------|-----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
|                                                                                                 |                                                                                                                                                                   |                                 |      |     | албадын дарга нарт зөвлөмж хүргүүлэн ажилласан.                                                                                                                                                                                                                                                                                     |    |
| 1.7                                                                                             | Дэд захирлууд, албадын дарга нарын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх                                                                              | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 70   | 85  | Тайлант хугацаанд БОЭТ-ийн дэд захирлууд, албадын дарга нар нийт 10 зорилт 70 үйл ажиллагааны хүрээнд 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлуулж хэрэгжилтийг улирал бүр үнэлүүлсэн. Хяналт үнэлгээний үр дүнг илтгэх хуудсаар байгууллагын Захиралд танилцуулж дэд захирлууд, албадын дарга нарт зөвлөмж хүргүүлэн ажилласан. | 90 |
| 1.8                                                                                             | Дээд шатны байгууллага болон бусад хамтын ажиллагаатай аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн хариутай бичиг, зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд үнэлгээ хийх | Шийдвэрийн хэрэгжилтийн хувь    | 98   | 100 | Тайлант хугацаанд нийт 205 бичиг ирсэнээс 43 буюу 20.9% нь хариутай бичиг байв. Хариутай бичгийн шийдвэрлэлт 80%. Хяналт үнэлгээний үр дүнг илтгэх хуудсаар байгууллагын Захиралд танилцуулж дэд захирлууд, албадын дарга нарт зөвлөмж хүргүүлэн ажилласан.                                                                         | 80 |
| <b>Хоёр. Байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хийх чиглэлээр</b> |                                                                                                                                                                   |                                 |      |     |                                                                                                                                                                                                                                                                                                                                     |    |
| 2.1                                                                                             | Байгууллагын “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх                                                                                | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 85   | 90  | Байгууллагын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хагас бүтэн жилээр үнэлгээ хийж удирдлагын зөвлөлд танилцуулж ажилласан. Хяналт үнэлгээний үр дүнг илтгэх хуудсаар байгууллагын Захиралд танилцуулж дэд захирлууд, албадын дарга нарт зөвлөмж хүргүүлэн ажилласан.                                                                  |    |
| 2.2                                                                                             | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх                                      | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь   | 77.8 | 90  | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтэд жилийн эцсээр үнэлгээ хийж байгууллагын удирдлагын                                                                                                                                                                                   | 90 |

|     |                                                                                                                                   |                                       |      |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |    |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------|------|----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
|     |                                                                                                                                   |                                       |      |    | зөвлөлөөр хэлэлцүүлэн ЭМЯнд хүргүүлсэн.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |    |
| 2.3 | Байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайланд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх                                                      | Вэб хуудасны хөгжүүлэлт Shilen.gov.mn | 47.8 | 90 | Байгууллагын цахим хуудас болон Shilen.gov.mn сайтын хөгжүүлэлтэд үнэлгээ хийж байгууллагын удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Өөрийн үнэлгээ эхний 11 сарын байдлаар 70% тай үнэлэгдсэн.                                                                                                                                                                                                                                            | 70 |
| 2.4 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтэд үнэлгээ хийх                                                     | Статистик үзүүлэлтийн хувь            | 63.1 | 80 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтэд хагас бүтэн жилээр үнэлгээ хийж байгууллагын удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн ЭМЯнд хүргүүлсэн.                                                                                                                                                                                                                                                                     | 80 |
| 2.5 | Үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд дотоод хяналт хийх                                            | Сэтгэл ханамжийн хувь                 | 46   | 80 | Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаа, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үнэлгээ 80% (тодорхой үр дүнд хүрсэн) дүгнэгдсэн. Мөн үйлчлүүлэгчийг эмнэлгийн орчинд албан бус төлбөрт өртсөн эсэхийг тодорхойлох зорилгоор 151 хэвтэн эмчлүүлэгчийг 12 асуулт бүхий судалгаанд хамруулахад бүрэн хариулсан 36 хүн, мөнгөн дүн болон ажилтан сонгоогүй асуултаа бөглөсөн 63 хүн, эхний 6 асуултад хариулаад цааш хариулаагүй 52 хүн байв. | 80 |
| 2.6 | Иргэн даатгуулагчдад үзүүлж буй тусламж үйлчилгээний чанар, гүйцэтгэлээр санхүүжих үйл ажиллагааны хэрэгжилтэд дотоод хяналт хийх | Гүйцэтгэлийн санхүүжилтийн хувь       | 81.3 | 85 | Монгол Улсын Засгийн газрын 2011 оны Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах тухай 311 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 346 дугаар тушаалыг тус тус удирдлага болгон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол шийдвэр,                                                                                                                                           | 88 |

|     |                                                                                                                        |                                 |    |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |     |
|-----|------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------|----|----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
|     |                                                                                                                        |                                 |    |    | ЭМДЕГ-тай байгуулсан гэрээ болон эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах тухай ЭМС-ын 2023 оны А/79 дүгээр тушаал хэрэгжилтэд дотоод хяналт хийж 11 чиглэлээр зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилт 88%                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |     |
| 2.7 | Эмнэлгийн мэргэжилтний ёсзүй, харилцаа хандлагыг сайжруулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд дотоод хяналт хийх | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 85 | 90 | Монгол Улсын Засгийн газрын 2011 оны Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах тухай 311 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн тухай хуулийн 26.1, эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн хяналтын хорооны дүрмийн 3.1.2, Эрүүл мэндийн яамны дэргэдэх “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо”-ны 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус удирдлага болгон “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо”-ны бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаа, төлөвлөгөөний хэрэгжилтэд дотоод хяналт хийж 5 чиглэлээр зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилт 90% | 90  |
| 2.8 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын хэрэгжилтэд үнэлгээ хийх | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 70 | 80 | Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.2 дахь заалт, Эрүүл мэндийн яамны “Чиглэл хүргүүлэх тухай” 2024 оны 06 дугаар сарны 24 өдрийн 2/2746 албан бичиг, Орхон аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн 2024 оны 07 дугаар сарын 23 өдрийн 91 тоот албан бичиг, Орхон аймгийн Эрүүл                                                                                                                                                                                                                                                                                                                            | 100 |

|      |                                                                                                               |                                   |     |     |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |    |
|------|---------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------|-----|-----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
|      |                                                                                                               |                                   |     |     | мэндийн газрын 2024 оны 06 дугаар сарны 18 өдрийн 10-25-01/105/44 тоот албан бичгийг тус тус үндэслэн 14 бүлгийн хүрээнд 130 заалтад дотоод хяналт хийж 3 чиглэлээр зөвлөмж хүргүүлж ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт 100%.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |    |
| 2.9  | Байгууллагын санхүү бүртгэлийн үйл ажиллагаа, өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалтад дотоод хяналт хийх | Аудитын зөвлөмжийн хэрэгжилт      | 100 | 100 | Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, УСНББОУС, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуулийг тус тус удирдлага болгон төсвийн зарцуулалт, тайлагналт, анхан шатны бүртгэл хөтлөлт, хүний нөөцийн төлөвлөлт хангалт, сургалтын гэрээ, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, худалдан авах ажиллагааны журмын хэрэгжилт, мэргэжлийн байгууллагаас өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтэд дотоод хяналт хийж 10 чиглэлээр зөвлөмж хүргүүлж ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт 80%. Аудитын зөвлөмжийн хэрэгжилт 100% | 90 |
| 2.10 | Бусад байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд байгуулсан “ Гэрээний хэрэгжилт”-д хяналт үнэлгээ хийх        | Гэрээний хэрэгжилт                | 70  | 80  | Төлөвлөгөөт хяналт хийгдээгүй                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | 0  |
| 2.11 | Байгууллагын үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран ажилласан байдал, хамтын гэрээний хэрэгжилтийн үр дүн      | Хамтын гэрээний хэрэгжилтийн хувь | 90  | 90  | МУ-ын Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай, ҮЭ-үүдийн эрхийн тухай хуулиуд болон Хөдөлмөр, нийгмийн зөвшлийг хангах хоёр болон гурван талт хэлэлцээрүүдийг тус тус удирдлага болгон цалин хөлс                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          | 80 |

|                                                                                              |                                                                               |                         |    |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |    |
|----------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------|-------------------------|----|----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
|                                                                                              |                                                                               |                         |    |    | олговрын талаар 21 заалт, тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтийн талаар 7 заалт, хөдөлмөр эрхлэлтийн нөхцлөөр 2 заалт, мэргэшил дээшлүүлэх талаар 3 заалт, ХЭАБА-ын талаар 16 заалт, Хөдөлмөр эрхлэлтийн шинэ хэлбэр хэрэглэх, техник, технологийн дэвшил нэвтрүүлэх болон бүтцийн өөрчлөлт, хувьчлах тохиолдолд ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхолыг хамгаалах талаар 4 заалт, ҮЭ, түүний ажилтан, сонгуультнаас үйл ажиллагаа явуулах бололцоог хангах талаар 14 заалт, хоёр талт харилцааг хөгжүүлэх талаар 5 заалтад дотоод хяналт хийж 5 чиглэлээр зөвлөмж хүргүүлж ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт 80%. |    |
| <b>Гурав . Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг хангах зорилтын хүрээнд:</b> |                                                                               |                         |    |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |    |
| 3.1                                                                                          | Байгууллагын халдварын сэргийлэлт хяналтын үйл ажиллагаанд дотоод хяналт хийх | Төлөвлөгөөний хэрэгжилт | 80 | 85 | Халдвар судлаач эмч 2, тархвар судлаач 1, нийт 3 орон тоогоор Эмнэлзүй эрхэлсэн дэд захирлын удирдлаган дор халдварын сэргийлэлт хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. ХСХ-ын төлөвлөгөөний хэрэгжилт 90%. 2025 онд нийт 15 нэгжид агаарт болон арчдасны шинжилгээг тогтоосон хуваарийн хүрээнд давхардсан тоогоор 37 удаа авч шинжилгээний хариунд дүгнэлт хийж тасаг нэгжүүдэд зөвлөмж өгч ажиллаж байна. Мөн нян тээгчийн шинжилгээг төрөх-эмэгтэйчүүд, нярай, мэс засал, гэмтэл, ХАНТ, ЭХТ, НЛТ, ЦСБ болон бусад нийт 18 нэгжид                                                                  | 90 |

|     |                                                                                                                           |                              |    |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |    |
|-----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------|----|----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
|     |                                                                                                                           |                              |    |    | баталсан хуваарийн дагуу давхардсан тоогоор нийт 1443 ажилтанг хамруулахад 63 нян тээгч илэрсэн. Үүнээс 56 ажилтан 3 удаагийн шинжилгээ өгч деколонизаци хийгдсэн. Үлдсэн 7 ажилтан эмчилгээ хийлгэж байна. ЭТҮХХ 2023 онд 8, 2024онд 8, 2025онд 9 тохиолдол бүртгэгдэж хариу арга хэмжээг зохион байгуулж ажилласан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |    |
| 3.2 | Эмнэлгийн нас баралт, давтан хагалгаа, хүндрэлийн тохиолдлуудад хийсэн хэлэлцүүлэг, түүний шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх | Шийдвэрийн хэрэгжилтийн хувь | 70 | 80 | Нийт нас баралт 2025 оны эхний 11 сарын байдлаар 129 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд энэ өмнөх оны мөн үеэс 24 тохиолдолоор нэмэгдсэн. Хоног болоогүй нас баралтын 42, 8-24 цагийн доторх нас баралт 20 тохиолдол бүртгэгдсэн байна. Үндсэн оношийн зөрүү 3 тохиолдол бүртгэгдсэн нь 6.3% буюу 1.1% - иар буурсан бол Эмнэлгийн тусламж үйлчилгээний дутагдал 4 тохиолдол байгаа нь өмнөх оноос 1 тохиолдолоор өссөн байна. ЭМТҮЧАБ албанаас нийт 8 удаа нас баралт, үндсэн оношийн зөрүү, ЭТҮД тохиолдлуудыг хэлэлцүүлж нийт 48 шийдвэр гаргаж 86% хэрэгжүүлж ажилласан байна. Хяналт хийх хугацаанд давтан хагалгаа, хүндрэлийн тохиолдлуудад хэлэлцүүлэг хийгдсэн боловч дүгнэлт, шийдвэрийг ирүүлээгүй | 80 |
| 3.3 | Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдлийг үнэлэх                                                                         | Арга хэмжээний тайлан        | 70 | 80 | Яаралтай тусламжийн тасгаар үйлчлүүлэгчдэд төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлж буй байдалд 9 үзүүлэлт бүхий хяналтын                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   | 84 |

|     |                                                                                      |                              |    |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |    |
|-----|--------------------------------------------------------------------------------------|------------------------------|----|----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
|     |                                                                                      |                              |    |    | хуудсаар үнэлгээ хийхэд тусламж үйлчилгээ аваад ажиглалт хийсэн тохиолдлын дундаж хугацаа 40-100минут байна. Яаралтай тусламж авах зорилгоор 2 цагаас дээш хүлээсэн хүлээгдэл 67 буюу нийт үйлчлүүлэгчдийн 0,6%-ийг эзэлж үүнээс тасгуудад хэвтсэн нь 73%. Зөвлөмжийн хэрэгжилт 84%. Хүрсэн үр дүн: 2 цагаас дээш хүлээгдэл 0.4 хувиар буурсан.                                                                                                                             |    |
| 3.4 | Өвчний болон сувилгааны түүх бичилтийн стандартад түүврийн аргаар дотоод хяналт хийх | Стандартын хэрэгжилтийн хувь | 82 | 85 | Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журам, бүртгэлийн маягтыг шинэчлэн батлах тухай” А/611 дүгээр тушаалыг удирдлага болгон 86 өвчний болон сувилгааны түүхэнд дотоод хяналт хийж 16 чиглэлээр зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилт 80%                                                                                                                                                                                   | 80 |
| 3.5 | Эмнэлзүйн удирдамж, заавар, стандартын хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх               | Стандартын хэрэгжилтийн хувь | 80 | 85 | Байгууллагын хэмжээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах зорилгоор нийт 171 эмнэлзүйн стандарт, ЭМС-ын 164 тушаал журам, зааврыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрддөг. Эмнэлзүйн удирдамж зааврын хэрэгжилтийг үнэлэхдээ ЭМТҮЧАБА нь нийт 35 хяналтын хуудсыг ашиглаж байна. Эмнэл зүйн стандарт, заавар, удирдамжийн хэрэгжилт дотоод хяналт шалгалтаар 86.9%, хөндлөнгийн “Эмнэлгийн оношилгоо эмчилгээний чанар, аюулгүй байдлыг шалгах” | 85 |

|                                            |                                                                          |                              |    |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |    |
|--------------------------------------------|--------------------------------------------------------------------------|------------------------------|----|----|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
|                                            |                                                                          |                              |    |    | хяналтын хуудсаар эрсдэл үүсэх магадлалын хувь 38 дунд эрсдэлтэй үнэлэгдсэн бөгөөд ЭМГ-ын дэргэдэх Хяналт үнэлгээний хэлтсээс ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж гүйцэтгэлийн хяналтаар эрсдэл үүсэх магадлалын хувь 17 бага эрсдэлтэй үнэлэгдсэн.                                                                                                                                                                                                                                                                                                      |    |
| 3.5                                        | Эмчилгээний хоол үйлдвэрлэлийн стандартын хэрэгжилтэд дотоод хяналт хийх | Стандартын хэрэгжилтийн хувь | 75 | 85 | Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 17.2.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах тухай 311 дүгээр тогтоолыг тус тус удирдлага болгон Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/440 дугаар тушаал, хоол үйлдвэрлэлийн үйлчилгээний газарт тавих шаардлага MNS 4946:2019, хоол үйлдвэрлэлийн үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал MNS CAC RCP 39:2011 стандартын хэрэгжилтэд дотоод хяналт хийж 15 чиглэлээр зөвлөмж хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилт 80% | 80 |
| Зөвлөмжийн хэрэгжилтийн дундаж хувь -79.4% |                                                                          |                              |    |    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |    |

#### ТАЙЛАН БИЧСЭН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АЖИЛТАН

А.БАЯРХҮҮ